

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.НАРАНТУЯА

УГААС/9086331

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ “ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ

Үндэслэл:

Төгсөлтийн дараах “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг 2018 онд Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нийслэлийн Чингэлтэй Эрүүл мэндийн төвд анх олгож, 2 дах жилдээ сургалтыг зохион байгуулж байна.

Иймд Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 2.5.1.1, 3.4.25, 4.4, 4.5 дах заалтын хэрэгжилтийг хангах, Японы хамтын ажиллагааны ЖАЙКА олон улсын байгууллагын үнэлгээний багийн зөлөмжийн дагуу төгсөлтийн дараах “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхэлж буй сургалт эрхлэх байгууллагын сургалтын үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээ хийн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах шаардлагатай байна.

Зорилго:

Төгсөлтийн дараах “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхэлж буй сургалт эрхлэх байгууллагын сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинтой танилцаж, үнэлгээ хийн, мэргэжил арга зүйгээр хангах

Үнэлгээний шалгуур:

Сургалтын албаны үйл ажиллагаатай танилцах

1. Сургалтын орчинг үнэлэх
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт
3. Ажлын байрны сургалтын зохион байгуулалт
4. Танхимын сургалтын зохион байгуулалт
5. Яаралтай тусламжийн сургалтын зохион байгуулалт
6. Сургалт дах эмнэл зүйн сургалтын оролцоо
7. Суралцагч эмчийн үнэлгээ
8. Сургалтын хяналтын үөвлөлийн үйл ажиллагаа

Хамрах хүрээ:

- Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сургалт эрхлэх сүлжээ эмнэлгүүд
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, сургалт эрхлэх сүлжээ эмнэлгүүд

Хугацаа: 2020 оны 2 дугаар сард

Үнэлгээ хийх бүрэлдэхүүн:

Д.Баярмаа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
Н.Сэвжид	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны дарга
П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн
Я.Бадамсүрэн	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны мэргэжилтэн
Д.Баярхүү	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны мэргэжилтэн
Ж.Жавхаа	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сургалтын албаны дарга /зөвшилцсөнөөр/

Үр дүн:

1. “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхэлж буй сургалт эрхлэх 2 байгууллагын сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинд явцын үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулж, хүргүүлсэн байна.
2. Сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангасан байна.

Хянасан:

Боловсруулсан:

Н. Сэвжид
П. Эрхэмбаяр

Н.Сэвжид /ХНБЗА-ын дарга

П.Эрхэмбаяр /ХНБЗА ахлах

мэргэжилтэн/